



МОНГОЛ УЛСЫН  
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Г Стратеги төлөвлөгөө батлах тухай Г

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Соёлын яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн яамны төсөвт тусган ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Г.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

Гурав. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 2 жил тутамд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хэрэгжилтийн тайланг танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /В.Жавзан/-т үүрэг болгосугай.

САЙД



Ч.НОМИН

152010076



**СОЁЛЫН ЯАМ**

**СОЁЛЫН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2021 - 2024 он)**

Улаанбаатар хот, 2021 он

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
СЯ	Сангийн яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
СоЯ	Соёлын яам
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ТББ	Төрийн бус байгууллага

## **СОЁЛЫН ЯАМНЫ 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшинг баримтлан Соёлын яамны ерөнхий чиг үүргийн хүрээнд 9 зорилт, 56 арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлнэ.

Дээрх зорилт, стратеги арга хэмжээг хэрэгжүүлэхэд яамны хүний нөөц болон хөрөнгө санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, үйл ажиллагааны үр дүнг үр нөлөө бүхий байдлаар төлөвлөж, дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангахаар Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад “Салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулна” гэж заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг баримтлан Соёлын яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

### **Хоёр. Мандатын шинжилгээ**

Мандатыг тодорхойлохдоо чиг үүргийн шинжилгээ хийж, Монгол Улсын Үндсэн хууль болон Соёлын салбарт шууд хамаарах 16 хууль, Олон Улсын гэрээ конвенц, төрийн алба, яамны эрхлэх асуудал, төсөв санхүү зэрэгт хамаарах 22 буюу нийт 38 хуулийн хүрээнд Соёлын яам болон салбарын бусад байгууллагуудад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан авч үзэн, дараах дөрвөн алхмын хүрээнд шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зэрэг ажлууд орсон.

Мандатын шинжилгээний үр дүнд 7 ерөнхий чиг үүрэг, 12 үндсэн чиг үүрэг, 44 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, доорх хүснэгтээр үр дүнг нэгтгэв:

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		38
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо: 16	<ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Үндсэн хууль;</li> <li>2. Соёлын тухай;</li> <li>3. Соёлын өвийг хамгаалах тухай;</li> <li>4. Номын сангийн тухай;</li> <li>5. Музейн тухай;</li> <li>6. Монгол хэлний тухай;</li> <li>7. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай;</li> <li>8. Засгийн газрын тусгай сангийн тухай;</li> <li>9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай;</li> <li>10. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай;</li> <li>11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай;</li> <li>12. Хууль тогтоомжийн тухай;</li> <li>13. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай;</li> <li>14. Садар самуун явдалтай тэмцэх тухай;</li> <li>15. Эрдэнэсийн сангийн тухай;</li> <li>16. Боловсролын тухай хуулиуд.</li> </ol>
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо:22	<ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Засгийн газрын тухай;</li> <li>2. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай;</li> <li>3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай;</li> <li>4. Захиргааны ерөнхий;</li> <li>5. Эрүүгийн;</li> <li>6. Зөрчлийн тухай;</li> <li>7. Төсвийн тухай;</li> <li>8. Нягтлан бодох бүртгэлийн тухай;</li> <li>9. Шилэн дансны тухай;</li> <li>10. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай;</li> <li>11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай;</li> <li>12. Төрийн албаны тухай;</li> <li>13. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай;</li> <li>14. Төрийн хяналт шалгалтын тухай;</li> <li>15. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай;</li> <li>16. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай;</li> <li>17. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай;</li> <li>18. Олон улсын гэрээний тухай;</li> <li>19. Инновацийн тухай;</li> <li>20. Патентын тухай;</li> <li>21. Оюуны өмчийн тухай;</li> <li>22. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхий тухай хуулиуд.</li> </ol>
<b>Ерөнхий чиг үүрэг 1: Соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах</b>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, салбарын	1/Соёлын салбарын хөгжлийн бодлого, стратегийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхойлох, боловсруулах, төлөвлөх.	ЗГХЭГ, яамд, аймаг, нийслэл, сум, дүүргийн

хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох	2/Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх.	Засаг дарга, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	3/Соёлын засаглал, тогтолцоог төлөвшүүлэх, дижитал шилжилт хийх.	
ҮЧҮ-2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох	4/Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт боловсруулах, төлөвлөх.	СоЯ, ЗГ
	5/Соёлын чиглэлээр МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг хангах.	СоЯ, ГХЯ
	6/Соёлын салбарт шаардлагатай мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, соёлын статистикийг олон улсын аргачлалын дагуу боловсруулах, батлуулах.	СоЯ, ҮСХ, бусад
ҮЧҮ-3. Нэгдсэн удирдамжаар хангах	7/Салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг нэгдсэн удирдамжаар хангах.	СоЯ
	8/Төсөвт соёл, урлагийн байгууллагуудын менежментийн загварыг шинэчлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.	СоЯ
<b>Ерөнхий чиг үүрэг 2: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх</b>		
ҮЧҮ-4. Соёл, урлагийг хөгжүүлэх, дэмжих	9/Эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан, гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх.	ЗГХЭГ, яамд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	10/Кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх.	
	11/Соёл судлалыг хөхиүлэн дэмжих.	
	12/Хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох соёл, урлагийн бүтээлийн зэрэглэл, жагсаалт, хэрэгжүүлэх журмыг тогтоох.	
	13/Соёлын тоо бүртгэл хөтөлж, дүн шинжилгээ хийх.	
	14/Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх.	
	15/Утга соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалах, өвлүүлэх, судалж сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, утга соёлын өвийг өвлөн тээгч билиг авьяастныг судлан тодорхойлж, эрдэм авьяасыг нь хойч үед уламжлуулахад туслан дэмжлэг үзүүлэх.	
	16/Ардын язгуур урлагийн чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.	
	17/Дүрслэх урлаг, уран барилга, дизайны чиглэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах.	
	18/Соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх.	
19/Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх.		
<b>Ерөнхий чиг үүрэг 3: Үндэсний өв, соёлыг хамгаалах, сэргээх, өвлүүлэх.</b>		
ҮЧҮ-5. Соёлын өвийн менежментийн	20/Үндэсний түүх, соёлын өвийг эрдэм судлал эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх.	ЗГХЭГ, яамд, аймаг, нийслэл,

<p>үндэсний тогтолцоо бүрдүүлэх</p>	<p>21/Хүн амд соёлын өвийн боловсрол олгох, сурталчлан таниулах.</p> <p>22/Соёлын биет бус өвд суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.</p> <p>23/Монгол үндэсний түүх, соёлын өвийг олон улсад сурталчлан таниулах</p>	<p>сум, дүүргийн Засаг дарга, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд</p>
<p><b>Ерөнхий чиг үүрэг 4: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх.</b></p>		
<p>ҮЧҮ-6. Соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх</p>	<p>24/Соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх.</p> <p>25/Соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх.</p> <p>26/Соёлын өвд суурилсан соёлын инноваци, үндэсний брэндийг бий болгох.</p> <p>27/Соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц (парк, инкубатор, хаб г.м)-ийг хөгжүүлэх, технологийн чадавхыг дээшлүүлэх.</p> <p>28/Бүтээлч үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, бүтээлч нэмүү өртгийн сүлжээ, бизнес эрхлэлтийг дэмжих.</p>	<p>ЗГХЭГ, яамд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд</p>
<p><b>Ерөнхий чиг үүрэг 5: Соёл, урлагийн ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.</b></p>		
<p>ҮЧҮ-7. Монгол үндэсний соёлыг олон улсад сурталчлан таниулах, нөлөөллийг нэмэгдүүлэх</p>	<p>29/Үндэсний түүх, соёлын өв, ардын урлагийг нэг цонхны бодлогоор сурталчлах.</p> <p>30/Соёлын олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох.</p> <p>31/Соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдийн олон улсын шилжилт хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжих.</p> <p>32/Соёлын гадаад худалдааг салбар дундын хамтын ажиллагаагаар дамжуулан дэмжлэг үзүүлэх.</p> <p>33/Олон улсын чанартай фестиваль, наадам, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.</p>	<p>ЗГХЭГ, яамд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд</p>
<p><b>Ерөнхий чиг үүрэг 6: Соёлын салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүй, үйл ажиллагааны тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ.</b></p>		
<p>ҮЧҮ-8. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах</p>	<p>34/Салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах.</p>	
<p>ҮЧҮ-9. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах</p>	<p>35/Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлох, хууль тогтоомжийг сайжруулах саналыг боловсруулах.</p> <p>36/Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох сургалт, сурталчилгаа хийх.</p>	<p>СоЯ, харьяа байгууллагууд болон бусад</p>
<p>ҮЧҮ-10. Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p>	<p>37/Төрийн захиргааны төв байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, төлөвлөх.</p>	<p>СоЯ</p>
<p><b>Ерөнхий чиг үүрэг 7: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, яамны хүний нөөц, санхүү, технологийг үр ашигтай удирдах.</b></p>		
<p>ҮЧҮ-11. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх</p>	<p>38/Төсвийн ерөнхийлөн захирагчаас бусад байгууллагатай харилцах, аймаг нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулах, явц үр дүнд хяналт тавих, дүгнэх.</p>	<p>СоЯ, харьяа байгууллагууд болон бусад</p>

	39/Салбарын болон салбар дундын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.	
	40/Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах.	СоЯ, харьяа байгууллагууд
ҮЧҮ-12. Хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдах	41/Салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, хүний нөөцийг үр ашигтай удирдах.	СоЯ, СЯ болон бусад
	42/Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх.	
	43/Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах.	
	44/Шаардлагатай бусад нөөцийн судалгаа гаргах, нөөцийг үр ашигтай удирдах төлөвлөлт хийх.	

### **Гурав. Алсын хараа**

Монгол соёлын үнэт зүйлийг хүн төрөлхтөнд тунхаглан тогтоож, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв бүхий үндэстэн улс болно.

### **Дөрөв. Эрхэм зорилго**

Биет болон биет бус соёлынхоо уламжлалыг өвлүүлэн дэлгэрүүлж, хүн төрөлхтний шилдэг ололттой хослуулан соёл, урлагаа хөгжүүлж дэлхийд өрсөлдөх бүтээл туурвил төрөн гарах нөхцөлийг сайжруулж, хэл, түүх, соёлоороо бахархан эх орноо хайрлах үзэл ухамсрыг төлөвшүүлэн түгээж үндэстний соёлын үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

### **Тав. Орчны шинжилгээ**

Соёлын яам 2021-2024 онд баримтлах стратеги төлөвлөгөөгөө боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад орчны хүчин зүйлс ихээхэн үр нөлөөтэй тул дараах орчны шинжилгээний дүгнэлт, үр дүнд тулгуурлан стратегийн зорилго, зорилт, үйл ажиллагаагаа тодорхойллоо.

#### **Дотоод орчны шинжилгээ:**

Яамны бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн хувьд:

- Төвлөрлийг сааруулах;
- Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах;
- Чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах;
- Үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх;
- Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд хийгдсэн.

#### **Гадаад орчны шинжилгээ:**

Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, технологи, хууль эрх зүй, хүрээлэн буй орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлох аргачлалаар ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг тооцоолсон.



**СОЁЛЫН ЯАМНЫ ДОТООД БОЛОН ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮР ДҮНГ НЭГТГЭСЭН СВОТ ШИНЖИЛГЭЭ**

<b>ДОТООД ОРЧИН</b>	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрийн манлайлал.</li> <li>• Соёлын салбарын олон төлөөлөл УИХ-д сонгогдсон.</li> <li>• Бие даасан яамтай болсон.</li> <li>• Соёлын үйлдвэрлэл инноваци хөгжих боломж бүрдсэн.</li> <li>• Соёлын салбарынхны бүтээлч хандлага.</li> <li>• Бүх нийтийн соёлын боловсролыг хариуцсан бодлогын газартай болсон.</li> <li>• Засаг захиргааны бүх нэгжид номын сан, театр, чуулга, музей, соёлын төв, соёлын ордонтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн чадавх, олон улсын хэмжээнд өрсөлдөх, хамтран ажиллах туршлага бага, бодлогын идэвхжүүлэлт сул.</li> <li>• Салбарын хамтын ажиллагаа, түншлэлийн механизм бүрэн бүрдээгүй.</li> <li>• Чиг үүргийн уялдаа холбоо хангалтгүй, зорилго тодорхой бус.</li> <li>• Хүний, санхүүгийн болон материаллаг нөөцийн хуваарилалт уялдаагүй.</li> <li>• Бүтэц зохион байгуулалт оновчгүй, ажил үүргийн хуваарь тэнцвэргүй.</li> <li>• Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр байхгүй.</li> <li>• Хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх боломжгүй.</li> </ul>
<b>ГАДААД ОРЧИН</b>	
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• УИХ, Засгийн газрын зүгээс соёлын салбарт онцгой анхаарч байна.</li> <li>• Соёлын салбарын иж бүрэн эрх зүйн орчин бүрдэж байна.</li> <li>• Соёлын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдсэн.</li> <li>• Олон улсын стандартын томоохон бүтээн байгуулалтыг дагаад шинэ дэвшилтэт техник технологи нэвтэрч байна.</li> <li>• Соёл урлагийн байгууллагууд өөрийн орлогоо захиран зарцуулах эрхтэй болсон.</li> <li>• Олон улсын гэрээ, конвенцууд Монгол улсын соёлын салбарт олон боломжуудыг бий болгосон.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Яамны нэгдсэн тогтолцоо нь өмнөх тогтолцооноос бүрэн гүйцэд салаагүй.</li> <li>• Ковид-19 цар тахлын нөлөөллөөс салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орж, орлогын хэмжээ буурсан.</li> <li>• Чөлөөт уран бүтээлчдэд шаардлагатай дэмжлэг хангалтгүй.</li> <li>• Оюуны өмчийг үнэлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах механизм бүрдээгүй.</li> <li>• Салбарын цахимжилт, мэдээллийн сан бүрдүүлэлт бүрэн хийгдээгүй.</li> <li>• Салбарын бүртгэл, мэдээлэл, статистикийн мэдээ бүрдүүлэлт, ашиглалт хангалтгүй.</li> <li>• Техник, тоног төхөөрөмж хоцорсон.</li> <li>• Нарийн мэргэжлийн сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах үйл ажиллагаа дутмаг.</li> <li>• Бүх нийтийн соёлын боловсролын түвшин доогуур.</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• 2018 оноос хойш соёлын ажилтны цалин 32-52 хувиар нэмэгдсэн.</li> <li>• Шашны зөрчилдөөний асуудал байхгүй.</li> <li>• Шинэ үеийн залуучууд орчин үеийн техник технологийн хэрэглээг хурдан хүлээн авах төрмөл авьяастай.</li> <li>• Соёлын өвд тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.</li> <li>• Бүс нутгийн түүх соёлын дурсгалт газрыг түшиглэсэн соёлын аялал жуулчлалын бүтээн байгуулалт эхэлсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг олон улсын зах зээл, нэмүү өртгийн сүлжээнд холбох тогтолцоо бүрдээгүй.</li> <li>• Үндэсний брэнд болсон соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хангалтгүй.</li> <li>• Соёлын салбарын оролцогчдыг дэмжсэн эрх зүйн орчин сул /татварын хөнгөлөлт г.м./.</li> <li>• Соёлын биет өвийн хамгаалалт сул.</li> </ul>
---	---

## **Зургаа.Стратегийн зорилго**

Үндэсний өв соёл, түүх, урлагийн үнэ цэнийг бүс нутгийн хэмжээнд өсгөх, хүн амыг соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн соёлын үйлчилгээг өргөтгөх, олон улсын жишигт нийцсэн дэд бүтцийг бий болгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, соёлын цогц тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэхэд оршино.

Энэхүү стратегийн зорилгын хүрэх үр дүнг дараах зорилтуудаар 2021-2024 онд хэрэгжүүлэхээр тодорхойллоо. Үүнд:

**Стратегийн зорилт-1.** Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

**Стратегийн зорилт-2.** Соёлын салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дижитал шилжилтийг хийнэ.

**Стратегийн зорилт-3.** Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

**Стратегийн зорилт-4.** Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээг боловсруулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт-5.** Соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэх, бүс нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт-6.** Үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ.

**Стратегийн зорилт-7.** Олон улсын стандарт, шаардлагад нийцсэн соёлын барилга байгууламжийг ашиглалтад оруулж, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт-8.** Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт-9.** Соёлын бодлого ба үйл ажиллагааг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд идэвхжүүлж, олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөг баталсан:

СОЁЛЫН САЙД  
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө боловсруулсан:

СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
(албан тушаал)

Тэмдэг

СОЁЛЫН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 он)

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр, хэмжээ (сая төг)	
<b>Ерөнхий чиг үүрэг - 1:</b> Соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах; <b>Ерөнхий чиг үүрэг - 6:</b> Соёлын салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүй, үйл ажиллагааны тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ. <b>Үндсэн чиг үүрэг - 1:</b> Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох; <b>Үндсэн чиг үүрэг - 2:</b> Эрх зүйн орчныг боловсронгуй болгох; <b>Үндсэн чиг үүрэг - 3:</b> Нэгдсэн удирдамжаар хангах; <b>Үндсэн чиг үүрэг - 8:</b> Бодлогын хэрэгжилтийг зохицуулах; <b>Үндсэн чиг үүрэг - 9:</b> Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах; <b>Үндсэн чиг үүрэг - 10:</b> Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Соёлын тухай шинэчилсэн батлуулна.	Соёлын тухай хуулийн найруулгыг батлуулна.	Соёлын тухай хууль 1996 онд батлагдсан.	Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан байна.	Улсын төсөв, 30.0	
	<b>Стратегийн зорилт 1.</b> Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	Музейн тухай сурталчилна.	Музейн тухай хуулийг батлуулна.	Арга хэмжээний тоо	Музейн тухай хуулийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 10-аас доошгүй удаа сурталчилсан байна.	Улсын төсөв, 30.0
		Кино урлагийг дэмжих тухай хуулийг батлуулна.	Кино урлагийг дэмжих тухай хуулийг батлуулна.	Батлагдсан хуулийн тоо	Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдсан байна.	Улсын төсөв, 30.0
		Соёлын үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн барина.	Хэрэгжилтийн хувь	-	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.	Улсын төсөв, 30.0

	Соёлын биет бус өвийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн барина.	Батлагдсан хуулийн тоо	-	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.	Улсын төсөв, 30.0
	Соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизм, бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.	Соёл, урлагийн нэгж байгуулагдсан тоо	-	21 аймагт Соёл, урлагийн нэгжийг байгуулан, байрны асуудлыг шийдвэрлэж үйл ажиллагааг тогтворжуулсан байна.	Улсын төсөв, 102,298.0
	Салбарын суурь судалгааг хийн хамрах цар хүрээний бүрэн зураглалыг гаргаж, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн тэргүүлэх, хамааралтай, дэмжих салбаруудын ангилал, үнэлгээг гаргана.	Судалгааны тайлангийн тоо	-	Судалгааны тайлан гарсан байна.	Улсын төсөв, 200.0
	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх "Монгол соёл, монголын баялаг" стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлнэ.	Баримт бичгийн тоо	-	Стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангасан байна.	Улсын төсөв, 30.0
	Олон улсын жишигт нийцсэн нэгдсэн судалгаанд үндэслэн мэдээллийн сан бүрдүүлнэ.	Мэдээллийн сангийн тоо	-	Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн сантай болно.	Улсын төсөв, 100.0
<b>Ерөнхий чиг үүрэг - 1: Соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах.</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 1: Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох.</b>					
<b>Стратегийн зорилт 2.</b> Соёлын салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дижитал шилжилтийг хийнэ.	"Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Дэд систем, сан, аппликэйшний тоо	Соёлын өвийн зарим мэдээллийн сан үүссэн.	Салбарын мэдээллийн 3 дэд систем, мэдээллийн 3 сан болон 1 аппликэйшн хөгжүүлсэн байна.	Улсын төсөв, 3,000.0
	"Дижитал яам" төсөл хэрэгжүүлнэ.	Хэрэгжсэн төслийн тоо	-	"Дижитал яам" төслийг хэрэгжүүлж, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан төрийн мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Улсын төсөв, 200.0
	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн статистик мэдээллийн боловсруулалтыг олон улсын жишигт нийцүүлж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэнэ.	Мэдээллийн сангийн тоо	-	Статистик мэдээллийн боловсруулалтыг олон улсын жишигт нийцүүлсэн мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.	Улсын төсөв, 200.0

	Соёлын салбарын үйл ажиллагааны үр дүнг тооцох үндэсний онцлогийг тусгасан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг судалгаан дээр үндэслэн бий болгоно.	Шалгуур үзүүлэлтийн тоо	-	Соёлын салбарын үйл ажиллагааны үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна.	Улсын төсөв, 100.0
<b>Ерөнхий чиг үүрэг - 7: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, яамны хүний нөөц, санхүү, технологийг үр ашигтай удирдах.</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 11: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх;</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 12: Хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдах.</b>					
<b>Стратегийн зорилт 3.</b> Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл, урлагийн салбарын хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.	Суралцсан оюутан болон мэргэжил дээшлүүлсэн соёлын ажилтны тоо	Гадаадад 5, дотоодод 30 оюутан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байна.	Гадаадын их дээд сургуульд оюутан, доошгүй 500-аас доошгүй соёлын ажилтан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна.	Улсын төсөв, 15,500.0
		Институтийн байр	-	Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийн байрны асуудлыг шийдвэрлэсэн байна.	
	Соёлын салбарын хамтын ажиллагаа, түншлэлийн олон талт хэлбэрүүдийг бий болгоно.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Соёлын салбар дахь түншлэлийн олон талт хэлбэрүүдийг бий болгож, соёлын форумыг зохион байгуулна.	Улсын төсөв, 500.0
<b>Ерөнхий чиг үүрэг - 2: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх.</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 4: Соёл, урлагийг хөгжүүлэх, дэмжих.</b>					
<b>Стратегийн зорилт 4.</b> Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээг боловсруулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын	"Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Арга хэмжээний тоо, биелэлтийн хувь	-	"Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг батлуулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэн, биелэлтийг 60 хувьд хүргэнэ.	Улсын төсөв, 12,070.0
	Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.	Арга хэмжээний тоо, монгол бичигтэй иргэдийн эзлэх хувь	0.02%	Монгол бичигтэй иргэдийн тоог 50%-д хүргэнэ.	Улсын төсөв, 400.0

дархлааг нэмэгдүүлнэ.	Монгол хэл бичгийн сан хөмрөгийг баяжуулах, хадгалж хамгаалах, судлан хөгжүүлэх, сурталчлан таниулах “Мэдээллийн сан” бүрдүүлнэ.	Мэдээллийн сан	-	Нутгийн аялгууны фонд, Монгол бичиг үсгийн дурсгалын атлас, Хүүхдийн үгийн сангийн нэгдсэн цахим “Мэдээллийн сан”-тай болно.	Улсын төсөв, 350.0
	Номын сангийн үйлчилгээг дижитал хэлбэрт шилжүүлэн иргэдэд хүрэх үйлчилгээний төрлийг олшруулж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	Нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь, үйлчилгээний төрөл, тоо	Цахим сан хөмрөгийн эзлэх хувь 0.49	Дижитал хэлбэрт шилжүүлэх шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, цахим сан хөмрөгийн эзлэх хувийг 5%-д хүргэнэ.	Улсын төсөв, 2,000.0
	Хэвлэл мэдээллийн салбарын үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.	Дэмжлэг үзүүлсэн нэвтрүүлгийн тоо	Энэ чиглэлээр нэгдсэн бодлогоор ажил хийгдээгүй.	Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, иргэдийг соён гэгээрүүлсэн нэвтрүүлгийн тоог 50-иар нэмэгдүүлсэн байна.	Улсын төсөв, 400.0
	Соёлын төв, соёлын ордны орчны төв, соёлын ордны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага, стандартыг батлуулж, стандартын шаардлага хангасан номын сан, соёлын төв, соёлын ордны тоог нэмэгдүүлнэ.	Стандартын тоо, шаардлага хангасан номын сан, соёлын төв, соёлын ордны тоо	Номын сангийн 1 стандарт, соёлын төвийн 2 судалгаа	Соёлын төв, соёлын ордны орчны стандарт батлагдаж, стандартын шаардлага хангасан нийт 10 номын сан, соёлын төв, соёлын ордонтой болсон байна.	Улсын төсөв, 800.0

**Ерөнхий чиг үүрэг - 3: Үндэсний өв, соёлыг хамгаалах, сэргээх, өвлүүлэх.**

**Үндсэн чиг үүрэг - 5: Соёлын өвийн менежментийн үндэсний тогтолцоо бүрдүүлэх.**

Стратегийн зорилт 5. Соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэх, бус нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.	Соёлын өвийг ЮНЕСКО-гийн дэлхийн өвийн болон соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлнэ.	ЮНЕСКО-гийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн газар, өвийн тоо	2019 оны байдлаар дэлхийн өвийн жагсаалтад 3, соёлын биет бус өвийн жагсаалтад 15 өв бүртгэгдсэн.	Дэлхийн өвийн жагсаалтад 4 газрыг, соёлын биет бус өвийг жагсаалтад 2 өвийг бүртгүүлэхээр нэр дэвшүүлнэ.	Улсын төсөв, 850.0
	Соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.	Нэгдэж орсон конвенцийн тоо	ЮНЕСКО-гийн соёлын өвийг хамгаалах 5 конвенцод нэгдэн орсон.	ЮНИДРУА-гийн конвенц болон Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцод нэгдэн орсон байна.	Улсын төсөв, 130.0
	Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулж, зэрэглэл тогтооно.	Бүртгэгдсэн баримтат, өвийн тоо	Иргэдэд хадгалагдаж байгаа баримтат өвийн бүртгэл байхгүй.	Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа 3,000-аас доошгүй баримтат өвийг бүртгэсэн байна.	Улсын төсөв, 788.0

	Хууль сахиулах байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх нэгж байгуулж, чадавхыг бэхжүүлнэ.	Шинээр байгуулагдсан нэгжийн тоо	Хууль хүчний болон хяналтын байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нэгж байхгүй.	Цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нэгжийг бий болгох талаар хамтран ажиллаж, соёлын өвийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай холбосон байна.	Улсын төсөв, 1,180.0
	Улсын хамгаалалтад байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулна.	Гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо	Улсын хамгаалалтын жагсаалтад 182 дурсгал орсон.	Улсын хамгаалалтад байгаа түүх, соёлын 50-иас доошгүй үл хөдлөх дурсгалыг хамгаалуулах гэрээг байгуулсан байна.	Улсын төсөв, 941.0
<b>Ерөнхий чиг үүрэг - 2: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх;</b>					
<b>Ерөнхий чиг үүрэг - 5: Соёл, урлагийн ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 4: Соёл, урлагийг хөгжүүлэх, дэмжих;</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 7: Монгол үндэсний соёлыг олон улсад сурталчлан таниулах, нөлөөллийг нэмэгдүүлэх.</b>					
	“Сонгодог урлаг-III” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	“Сонгодог урлаг II” үндэсний хөтөлбөр хэрэгжиж дууссан.	“Сонгодог урлаг III” арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Улсын төсөв, 6,945.0
<b>Стратегийн зорилт 6.</b> Үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ.	Хүүхдэд зориулсан уран бүтээлийн судалгаа хийж, уран бүтээлийн тоо болон урлагийн байгууллагаар үйлчлүүлэх хүүхдийн тоог тус тус нэмэгдүүлнэ.	Судалгааны тоо, уран бүтээлийн тоо, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	Судалгаа байхгүй, 2 уран бүтээл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь 8.1 %.	Судалгаа хийгдэж, 5-аас доошгүй уран бүтээл туурвин, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувийг 15%-д хүргэнэ.	Улсын төсөв 1,000.0
	Мэргэжлийн байгууллагын бүтэц орон тооны стандартыг батлуулж, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	Стандартын тоо, хэрэгжилтийн хувь	–	1 стандарт батлуулж, хэрэгжилтийг 50%-д хүргэнэ.	Улсын төсөв 1,000.0
	Салбарын олон нийтийн түншлэлийг өргөжүүлж, олон талт арга хэмжээг эрчимжүүлнэ.	Судалгааны тоо, гэрээ байгуулж хамтран ажилласан байгууллагын тоо	Судалгааны төсөл 1, зохион байгуулсан арга хэмжээ 5, дэмжлэг үзүүлсэн төсөл, арга хэмжээ 5, гэрээ байгуулсан мэргэжлийн холбоо 2 байна	Судалгаа гаргаж, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг 5-аас доошгүй салбарын мэргэжлийн холбоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг ТББ-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн байна.	Улсын төсөв 2,000.0



	Үндэсний кино урлагийг дэмжинэ.	Мэдээллийн сангийн тоо, олон уралдаан наадмын тоо, хөтөлбөрийн тоо, дэмжсэн уран бүтээлийн тоо	Кино урлагийг дэмжих тухай урлагийг төслийг өргөн барьсан.	Мэдээллийн сан 1, Олон улсын уралдаан наадам 3, дэмжлэг үзүүлсэн хөтөлбөрийг олон нийтэд түгээсэн телевиз, киноны байгууллага 5-аас доошгүй, дэмжлэг үзүүлсэн хамтарсан уран бүтээл 2-оос доошгүй, олон улсын кино наадамд 2-оос доошгүй уран бүтээлч оролцсон байна.	Улсын төсөв, 39,970.0
	Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг буй болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Хөтөлбөрийн тоо, хөг бүрдсэн симфони найрал хөгжмийн тоо, олон улсын уралдаан, наадмын тоо, дэмжлэг үзүүлсэн уран бүтээлчдийн тоо	Улсын хэмжээний 3 симфони найрал хөгжмийн хөг дутуу, уралдаан наадам 1, уран бүтээлчид 10,	Мэргэжлийн урлагийн байгууллагын стратеги, менежментийн шинэчлэлийн хөтөлбөрийг баталж, 3 симфони найрал хөгжмийн хөгийг бүрдүүлнэ. Олон улсын хэмжээний уралдаан наадмыг эх орондоо зохион байгуулж, 20-иос доошгүй уран бүтээлчдэд гадаадад зохиогддог уралдаан наадамд оролцоход дэмжлэг үзүүлсэн байна.	Улсын төсөв, 8,600.0
<b>Ерөнхий чиг үүрэг - 2: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх;</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 11: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх</b>					
<b>Стратегийн зорилт 7.</b> Олон улсын стандарт, шаардлагад нийцсэн соёлын барилга байгууламжийг ашиглалтад оруулж, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	“Чингис хаан” хаад, язгууртны шинэ музейг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Барилга угсралтын ажил 70 хувьтай.	Музейн барилгыг бүрэн ашиглалтад оруулж, шилэн хорго, витрин, тоног төхөөрөмжөөр тохижуулан, дэглэлтийг хийсэн байна.	Улсын төсөв, 29,085.0
	Байгалийн түүхийн шинэ музейг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Газар, техникийн нөхцөл, барилгын ажлын зураг төсөл хийх асуудлууд шийдэгдсэн.	Барилгыг бүрэн ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 101,460.0
	Үндэсний номын сангийн шинэ барилгыг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Барилга угсралтын ажил 80 хувьтай.		Улсын төсөв, 11,340.0
	Үндэсний урлагийн их театрын шинэ барилгыг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Зургийн даалгаврыг боловсруулж,		Улсын төсөв, 197,520.0

				газрын асуудлыг шийдвэрлэсэн.			
Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилгыг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Барилга угсралтын ажлын хувь	Газрын асуудал шийдэгдсэн.	Газрын асуудал шийдэгдсэн.	Барилгыг бүрэн ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 23,000.0	
Хөвсгөл нуурыг түшиглэсэн "Хөвсгөл нуур музей, соёл мэдээллийн төв"-ийг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Барилга угсралтын ажлын хувь	Газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсөл байхгүй.	Газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсөл байхгүй.	Барилгыг бүрэн ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 13,000.0	
"Төв Азийн түүх, соёлын голомт" судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолборыг Орхон-Тамир, Хануй-Хүнүйгийн дурсгалуудыг түшиглэн байгуулна.	Цогцолборын тоо	Цогцолборын тоо	Бодлогын баримт бичигт тусгагдсан	Бодлогын баримт бичигт тусгагдсан	Цогцолборыг ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 18,400.0	
Түүхэн дурсгалт барилга байгууламж, барилга архитектурын дурсгалыг сэргээн засварлаж, хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөлийг сайжруулна.	Сэргээн засварлалтын гүйцэтгэлийн хувь, ашиглалтад орсон үзэсгэлэнгийн танхимын тоо	Сэргээн засварлалтын гүйцэтгэлийн хувь, ашиглалтад орсон үзэсгэлэнгийн танхимын тоо	Чойжин ламын сүм музейн цогцолборт хэсэгчилсэн сэргээн засварлалт хийсэн.	Чойжин ламын сүм музейн цогцолборт хэсэгчилсэн сэргээн засварлалт хийсэн.	Чойжин ламын сүм музейн сэргээн засварлалтыг бүрэн дуусгаж, сан хөмрөг, үзэсгэлэнгийн танхимын барилгыг ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 10,661.6	
Хүүхдийн номын сан, хүүхэддэйн театрыг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын хувь	Барилга угсралтын ажлын хувь	Газрын асуудал шийдсэн. Зураг төсөл байхгүй.	Газрын асуудал шийдсэн. Зураг төсөл байхгүй.	Барилгыг бүрэн ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 48,500.0	
Хүүхэд залуучуудын театрын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	Барилга угсралтын ажлын хувь	Барилга угсралтын ажлын хувь	Газрын асуудал шийдэгдээгүй. Зураг төсөл байхгүй.	Газрын асуудал шийдэгдээгүй. Зураг төсөл байхгүй.	Газрын асуудлыг шийдүүлж, зураг төслийг бэлэн болгон, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	Улсын төсөв, 20,500.0	
Байгалийн түүхийн музей /хуучнаар Лениний музей/-г шинэчлэн засварлана.	Их засварын ажлын гүйцэтгэлийн хувь	Их засварын ажлын гүйцэтгэлийн хувь	Их засварын зураг төсөл хийгдээгүй.	Их засварын зураг төсөл хийгдээгүй.	Их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.	Улсын төсөв, 3,000.0	
Үндэсний контент үйлдвэрлэлийн төвийн ТЭЗҮ-ийг боловсруулна.	ТЭЗҮ судалгааны тоо	ТЭЗҮ судалгааны тоо	Газрын асуудал, төсөл шийдэгдээгүй	Газрын асуудал, төсөл шийдэгдээгүй	ТЭЗҮ хийгдэж, зураг төслийг боловсруулан барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	Улсын төсөв, 30,400.0	
Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төв, орон нутгийн соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Театр, чуулгын барилгын тоо	Театр, чуулгын барилгын тоо	Архангай, Завхан аймгийн театрын барилга угсралтын ажил 80%, Увс аймгийн театр	Архангай, Завхан аймгийн театрын барилга угсралтын ажил 80%, Увс аймгийн театр	Орон нутагт нийт 6 театр, чуулгын барилгыг ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 101,482.4	

				70%, Хэнтэй аймгийн чуулга 90%, Дундговийн театр 5%-тай байна.					
	Музей, номын сангийн тоо	Дархан-Уул, Өмнөговь аймгийн номын сангийн газрын асуудлыг шийдүүлж, зураг төслийг боловсруулсан.	Мухай, номын сангийн тоо	2016-2020 онд 26 шинэ Соёлын төв ашиглалтад орсон	Дархан-Уул музей болон 2 аймгийн номын сангийн барилгыг ашиглалтад оруулна.	Улсын төсөв, 17,000.0			
	Соёлын төв, соёлын ордон		Соёлын төв, соёлын ордон	2016-2020 онд 26 шинэ Соёлын төв ашиглалтад орсон	3 соёлын ордон, 58 соёлын төвийг шинээр ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, 103,500.0			
<p><b>Ерөнхий чиг үүрэг - 1: Соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах;</b>  <b>Ерөнхий чиг үүрэг - 4: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх.</b>  <b>Үндсэн чиг үүрэг - 1: Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;</b>  <b>Үндсэн чиг үүрэг - 6: Соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.</b></p>									
<p><b>Стратегийн зорилт 8.</b>  Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.</p>	“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” /2022-2026/ арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	“Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр хэрэгжиж дууссан.		“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээний хэрэгжилтийг 50%-д хүргэнэ.	Улсын төсөв, 12,000.0			
	Үндэсний агуулгатай инноваци шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, язгуур урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.	Соёлын үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувийн өсөлт	Соёлын үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь 0.4			Соёлын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг 3-т хүргэнэ.	Улсын төсөв, 16,000.0		
	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ангиллыг бий болгож, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлно.	Соёлын үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувийн өсөлт	Соёлын үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь 0.4			Соёлын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг 3-т хүргэнэ.	Улсын төсөв, 100.0		
	Соёлын өвд суурилсан үндэсний брэндийг кластераар хөгжүүлнэ.	Кластерын тоо	-			Бүтээлч кластерын 2-оос доошгүй сүлжээ байгуулна.	Улсын төсөв, 10,000.0		
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулна.	Баримт бичгийн тоо				Цогцолборын ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.	Улсын төсөв, 2,000.0			

	"Монголд бүтээв" барааны тэмдгийг үүсгэж, үйлдвэрлэл, технологи, мэдлэг нэвтрүүлэх удирдлагын төвийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.	Удирдлагын төвийн тоо	-	Удирдлагын төвийг байгуулсан байна	Улсын төсөв, 10,000.0
	Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлдэг ААН-ийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх санхүүжилтийн оновчтой, үр ашигтай механизмыг бүрдүүлнэ.	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	-	Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлдэг 5-аас доошгүй аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн байна.	Улсын төсөв, 200.0
	Соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй холбоотой оюуны өмчийг хамгаалах эрх зүйн орчны нарийвчилсан судалгааг хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, шийдэл боловсруулна.	Судалгааны тоо	-	Соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй холбоотой оюуны өмчийг хамгаалах эрх зүйн орчны шийдэл боловсруулсан байна.	Улсын төсөв, 200.0
	"Бүтээлч монгол" хөрөнгө оруулалтын сан байгуулна.	Сангийн тоо		Хөрөнгө оруулалтын санг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	Улсын төсөв, 10,000.0
<b>Ерөнхий чиг үүрэг - 3: Үндэсний өв, соёлыг хамгаалах, сэргээх, өвлүүлэх;</b>					
<b>Ерөнхий чиг үүрэг - 5: Соёл, урлагийн ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.</b>					
<b>Үндсэн чиг үүрэг - 7: Монгол үндэсний соёлыг олон улсад сурталчлан таниулах, нөлөөллийг нэмэгдүүлэх.</b>					
<b>Стратегийн зорилт 9.</b> Соёлын бодлого ба үйл ажиллагааг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд идэвхжүүлж, олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.	Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах чиглэлээр олон улсын арга хэмжээ зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2018 онд "Нүүдэлчин Монгол" наадам зохион байгуулсан	Дэлхийн соёлын сайд нарын форум, Дэлхийн өвийн Засгийн газар хоорондын хорооны 46 дугаар чуулган болон Дэлхийн монгол угсаатны ардын урлагийн их наадам, "Нүүдэлчин Монгол" наадмыг тус тус зохион байгуулна.	Улсын төсөв, 8,240.0
	Монгол хэл, бичиг, соёлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх "Монголын соёлын төв"-ийг их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудыг түшиглэн байгуулна.	Байгуулсан соёлын төвийн тоо	-	Гадаад улсад 2 соёлын төв байгуулсан байна.	Улсын төсөв, 3,400.0

## Долоо. Хавсралт

### Стратегийн зорилго ба салбарын бүтцийн уялдаа, зураглал

